

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР  
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл 1. Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	3-9

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 14-ний өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Ж.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Д.Бат-Эрдэнэ;  
Чөлөөтэй: Т.Аюурсайхан, Х.Болорчулуун, Х.Ганхуяг.*

**Нэг.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндөн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндөн, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 52 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.ГАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР  
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Ганбаатар:** Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдааны ирц хүрсэн байна. Өнөөдрийн хуралдаан эхэлж байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулья.

**Нэг.Гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.**

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн танилцуулна. Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга эрхэм гишүүдээ,

Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн чуулганаар 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн санал тус бүрийг төсөлд нэмж тусгалаа.

Тухайлбал, зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан хуулийн төслийн нэр, гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай болж өөрчлөгдсөн. Нэр өөрчилсөнтэй холбогдуулан холбогдох өөрчлөлтүүдийг төсөлд нэмж тусгалаа. Төслийн 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж, 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулна” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж тус тус өөрчлөх саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан холбогдох өөрчлөлтүүдийг бас ажлын хэсгээс хийж өнөөдөр танилцуулж байна. Төсөлд зарим үг хэллэг, найруулгын шинжтэй засваруудыг хийсэн болно.

Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 67.1 дэх хэсэгт заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналуудыг төсөлд нэмж тусгасан. Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийн эцсийн хувилбарын төслийг Байнгын хорооны гишүүд та бүхэнд тараасан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулья. Жавхлан Сангийн сайд, Сангийн сайд одоо ороод ирнэ. Танхимд бас асуултад хариулж байгаа. Мэндсайхан Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Ёндон сайд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын захирал, Энхжин Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуултдаа Их Хурлын гишүүд нь нэрсээ өгөхийг хүсье. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Чинзориг гишүүн асуултаяа асууя. Цогтгэрэл гишүүнийг нэмээд оруулчихъя.

**С.Чинзориг:** Нэг асуулт байгаа юм. Өчигдөр хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулсантай холбогдуулаад хуралдааны төгсгөлд Их Хурлын даргаас ажлын хэсэгт тодорхой чиглэлүүд өгсөн шүү дээ. Тодорхой хэмжээгээр энэ бараа бүтээгдэхүүний үнийг бас тогтвортжуулахтай холбоотойгоор үйлдвэрлэгчидтэй уулзсан. Үйлдвэрлэгчдийн гаргасан санал гээд дөрөв, таван тодорхой чиглэл хэлсэн. Энэ чиглэлтэй холбоотой асуудлыг бид энэ хуульд өөрчлөлт орох арга, боломж байхгүй байх. Гэхдээ ер нь цаашдаа юун дээр нь анхаарч өөрчлөх юм? Төсвийн тодотгол орж ирэхлээр тэрэнд нь суулга ч гэх юм уу? Энэ хууль чинь ирэх жилийн мах, гурилын нөөц бүрдүүлэлттэй холбоотой харилцааг л зохицуулж байгаа болохоос биш яг гадна талд бараа, бүтээгдэхүүний хомстол үүсгэхгүй байх, үнийн хөөрөгдлийг зогсоох, тогтвортжуулах арга хэмжээ авах гэж байгаа юм байна гээд ийм хүлээлт үүсчихсэн байж байдаг.

Гэтэл одоо энэ баталж байгаа батлах гэж байгаа хууль чинь бол ирэх жилийн л нөөц бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа хууль байж байдаг. Тэгээд энэ иргэдийн энэ хүлээлтэд бас хариулт өгч чадахгүй болов уу гэж би бодоод байгаа юм. Тийм ч учраас бол Их Хурлын дарга өчигдөр анхны хэлэлцүүлэг явуулсны төгсгөл дээр бас тодорхой үйлдвэрлэгчтэй уулзсаны дагуу тодорхой чиглэлүүд өгсөн. Энийг ажлын сан анхаарарай гэдэг байсан. Энийг юу гэж тооцож, бодож байгаа юм бэ гэж.

Хоёр дахь асуудал нь санал байна. Энэ хөдөө аж ахуйн сайд байхгүй байх юм. Бид мах, гурил үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл өгөхөөр ингээд хууль батлах нь л дээ. Тэгэхээр энэ мах үйлдвэрлэгчид, гурил үйлдвэрлэгчид чинь эцсийн жижиглэн худалдааг явуулдаггүй. Жижиглэн худалдааг нь өөр аж ахуйн нэгж, байгууллагуудаар дамжуулан явуулдаг. Манайд чинь нэгдсэн бэлтгэн нийлүүлэлтийн систем байхгүй учраас эцсийн хэрэглэгч дээр очиж байгаа гурил махны үнэ нэмэгдэхгүй гэх тийм баталгаа байхгүй шүү дээ гэж би Эдийн засгийн байнгын хороон дээр ч бас ярьсан. Тэгэхээр энэ хөнгөлөлттэй зээлийг үйлдвэрлэгчид нь өгчхөж байгаа юм чинь тэднээс гэрээгээр жижиглэн худалдаа хийхээр авч аж ахуйн нэгжүүдтэйгээ хэрэглэгчдийн гар дээр очих мах, гурилын үнийг жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэхгүйгээр байх, тогтвортой байлгах энэ арга хэмжээг яаж зохицуулах гэж байгаа юм бэ? Би энд маш их санаа зовж байгаа юм.

Бараа бүтээгдэхүүний хомстол үүсгэхгүй байх, үнийг өсөлт гаргахгүй байх, үнийг тогтвортжуулахын хууль баталчихлаа гээд иргэд ингээд хүлээгээд байдаг. Тэгээд энэ чинь үйлдвэрлэгчдэд зээл өгчихөөр өөрсдөө жижиглэн худалдаа эрхэлдэггүй учраас тэр жижиглэн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд чинь үнээ нэмээд үнийн өсөлт гаргах, үнэ тогтвортжуулах гээд байх ийм асуудал гарах юм биш биз дээ гэдгийг бас Засгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн яам нэлээн анхаармаар байгаа юм. Би бол газрын тосны бүтээгдэхүүн импортлогч дээр ийм асуудал гайгүй болов уу гэж бодож байна. Импортлох гэж байгаа байгууллагууд өөрсдөө жижиглэнгийн худалдааг явуулдаг учраас тэр яамтайгаа гэрээ хийхэд болно. Энэ хуульд орж байгаа зохицуулалт чинь тэр мах, гурилтай холбоотой асуудал дээр чинь үйлдвэрлэгчтэйгээ гэрээ байгуулна гээд байгаа юм. Яг жижиглэн дээр, хэрэглэгч дээр очиж байгаа тэр асуудлыг зохицуулсан харилцаа байхгүй байгаад байгаа юм. Энэ дээр манай Хөдөө аж ахуйн яам, сайд бас нэлээн онц онцгой анхаарна биз дээ.

Хоёр дахь асуудал нь мах үйлдвэрлэгчид, гурил үйлдвэрчдэд зээл өгчихөөр яг үндсэн малчдыг яаж дэмжих юм, газар тариалан эрхлэгчдийг яаж дэмжих юм, үндсэн үйлдвэрлэлийг яаж дэмжих юм бэ гэдэг асуудлыг бас нэлээн сайн анхаармаар байгаа юм. Ийм хоёр саналыг бас зайлшгүй хэлье.

**Ж.Ганбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Тогтоолын төсөл дагаж зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх нөөц бүрдүүлэх чиглэлээр Их Хурлын дарга өчигдөр үүнийг ажлын хэсэг харж үзээрэй, Эдийн засгийн байнгын хороо анхаарч үзээрэй гэдэг ийм чиглэл бол өгсөн. Тэгээд ажлын хэсэг дээр бас бид нар энийг ярьсан. Ажлын хэсгийнхэн маань энэ хуулийн гол зорилго нь энэ гурван бүтээгдэхүүн дээр жишээ байгаа юм чинь гээд ингээд дэмжигдсэнгүй.

Ер нь бол энийг, би Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам байж байна, Уул уурхайн яам байж байна. 2008 оны 30 дугаар тогтоол гээд стратегийн нөөцийн бараа материалын нэр төрөл батлах тухай гээд Их Хурлын тогтоол байдаг юм байна. Ер нь энийг нэг шинэчилж батлаад үүнийхээ нөөцийг бүрдүүлэх талаар төр, хувийн хэвшилтэйгээ ингэж ажиллаж байна гээд, та бүхэн маань бид нар чинь ард түмэн дайн болж байна, урд хил хаагдчихсан байна, бид нар та бүхэн маань ойлгооч ээ гээд байдаг. Энэ ажлуудаа бид нар бас цаг тухайд нь хийгээд явахгүй бол дандаа нэг удаагийн шинж чанартай хуулиудаар арга хэмжээнүүдээр ингээд аргацаагаад яваад байх нь бол буруу юм.

Энэ стратеги, энэ чинь аль 2008 оных учраас жишээлбэл, энэ дээр цэвэр зэс, угаасан ноолуур. Энэ өнөөдөр дайн байлдааны үед стратегийн нөөцийн муугүй юм уу, одоо мэдэх юм алга. Ёoton ч гэж байх шиг. Энийг одоо шинэчлэх цаг нь болчихсон юм биш үү?

Дээрээс нь нэмээд мах, хүнсний ногооны хангамж хүртээмжийг тогтвортой байлгах дээр дотоодын зах зээл дээр үнэ бууруулах зорилгоор, үйлдвэрлэгчдээ дэмжих зорилгоор бас үе шаттай төлөвлөгөө боловсруул гээд. Энэ ажлуудыг уг нь энэ хуультай, хуульгүй хийгээд, ядаж Эдийн засгийн байнгын хороонд, дээрээс нь нэмээд Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороондоо танилцуулаад явах нь бол зүйтэй байх аа. Энэ чинь иргэд, олон нийтэд мэдээлэл яг нээлттэй хүрч байгаа нэг илрэл л дээ. Тэгээд би бол одоо тогтоолыг бол дагуулаад гаргая гэсэн. Харамсалтай нь ажлын хэсэг дээр энэ бол дэмжигдээгүй.

**Ж.Ганбаатар:** Хүнс, хөдөө аж ахуйн сайд чуулган дээр хариулж байгаад орж ирлээ л дээ. Чинзориг гишүүн, 2 минут нэмж өгье.

**С.Чинзориг:** Мэндсайхан сайд аа, ийм л зүйл яриад байгаа юм л даа, бид. Одоогийн энэ баталж байгаа хууль чинь бол үндсэндээ ирэх оны л мах, гурилын нөөц бүрдүүлэхтэй холбоотой харилцаагаа зохицуулаад байна л даа. Тэгээд гадна талд чинь Засгийн газар хууль өргөн барьсан, Их Хурал хууль батлахаа болчихлоо. Бараа, бүтээгдэхүүний хомстол үүсэхгүй юм байна, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бас тогтворжих юм байна гэсэн ийм хүлээлт байгаад байдаг. Энэ дээр та бүхэн ямар хариулт өгөх юм бэ?

Хоёр дахь асуудал нь мах, гурил үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр Засгийн газраас хүүгийн татаасыг нь өгөөд зээл олгоно гэсэн гол харилцааг л зохицуулж байгаа юм. Тэгэхээр та бүхэн үйлдвэрлэгчтэйгээ гэрээ байгуулна гэсэн ийм харилцаа зохицуулалт орж байгаа юм. Гэтэл махны үйлдвэрүүд, гурилын

үйлдвэрүүд чинь жижиглэн худалдааг өөрсдөө бол хийдэггүй. Газрын тосны бүтээгдэхүүн бол болох болов уу гэж бодож байна. Импортлогч өөрсдөө жижиг худалдаагаа хийчихдэг. Мах, гурилын үйлдвэрлэгч чинь жижиглэн худалдааг хийдэггүй. Тэгсэн атлаа махны үнийг тогтвортжуулна гээд, гурилын үнэ тогтвортжуулна гээд хөнгөлөлттэй зээл авчихдаг. Яг эцсийн жижиглэн худалдааг аж ахуйн нэгж, байгууллагууд, өөр аж ахуйн байгууллагууд хийдэг. Та сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ маань иргэдийн гар дээр очиж байгаа жижиглэнгийн үнэ нэмэгдэхгүй гэх баталгаа байж чадах уу, үгүй юу? Үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл өгчихөд, тэрний чинь үр шимиийг яг хэрэглэгчид бодитойгоор хүртэж чадах уу, үгүй юу? Дунд нь ченжүүд нь юм уу, үгүй бол нөгөө жижиглэн худалдаа хийж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд чинь үнийн өсөлт гаргаад, ингээд бидний гаргаж байгаа энэ хууль чинь эзнээ олохгүй, байгаа болохгүй бас нэг зөвхөн үйлдвэрүүдийг дэмжсэн ийм арга хэмжээ болчих вий дээ гэж би болгоомжлоод байгаа юм. Энэ дээр одоо та бүхэн ямар зохицуулалт хийх юм бэ? Энийг нь нэлээн сайн анхаармаар байх юм.

**Ж.Ганбаатар:** Мэндсайхан сайд, ажлын хэсэг, 7 номер.

**3.Мэндсайхан:** Чинзориг гишүүний асуултад хариуљя. Тэгэхээр энэ хууль батлагдан гарснаараа бид нар ирэх оны махны болон гурилын хэрэглээг тогтвортой байлгах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэл дээрээ эртнээс арга хэмжээ авч байгаа хэрэгжүүлье гэж байгаа юм. Та өөрөө мэдэж байгаа. 7 сарын 1 хүртэл бид нар нөөцийн мах бэлтгэсэн. Энүүгээрээ 7 сарын 1 буюу шинэ мах гартал явчихъя гэж байгаа юм. Энэ өөрөө яагаад үр дүнтэй байна вэ гэхээр одоо хүнсний захуудаар нийлүүлэгдэж байгаа махны үнэ 10 мянгаас 12500-гийн хооронд байна, ястай үхрийн мах гэхэд. Гэтэл нөөцийн махаар бэлтгэсэн мах өнөөдөр зах зээл дээр нь 8900 төгрөгөөр гарч ирж байна л даа. Тэгэхээр бид нар мал, мах маань хямд байгаа үед энэ аж ахуйн нэгжүүддээ мал, махаа бэлтгэх нөхцөлийг нь бүрдүүлж өгөхөөр л энэ зээл эргэлтийн зээлийг гаргаж байгаа юм.

Мал мах бэлтгэх хугацаа чинь бол одоо энэ зээл гараад л, гарсан өдрөөсөө хэрэгжүүлээд явах боломжтой. Тэгэхээр бид нар намрын мах бэлтгэлийн үе буюу тэр нийлүүлэлтийн үетэй нь давхцаж, зээл гаргаж махны үнийг хөөргөж байхаар эртнээс энэ бэлтгэлийн ажлыг нь аж ахуйн нэгжүүддээ дэмжлэг болгоод өгчихье, ингээд нийлүүлэлт талдаа бид нар нөөц бүрдүүлчих юм бол зах зээлийнхээ хуулиар нийлүүлэлтийнхээ нөөцийнхөө юун дээр тулгуурласан үнийн бодлого явчихна гэж харж байгаа. Түүнээс биш, яг төдөн төгрөгөөр махны үнийг буулгана болгоно, гурилын үнийг буулгана гэсэн амлалт биш. Бид нар ерөнхийдөө нөөц болон нөөц бүрдүүлэх боломжийг нь үйлдвэрлэгч, тариаланчид малчдадаа олгоё л гэж байгаа. Тариаланчдад бол зориулсан зээлээ Засгийн газар 3 хувийн хүйтэй гаргачихсан. Нөгөө талдаа боловсруулах үйлдвэрүүд, гурилын үйлдвэрүүдэд нь зээлийг нь гаргаад явж байгаа ийм л нөөц бүрдүүлэлтийн ийм ажил байгаа.

Зүгээр, жижиглэнгийн худалдааны асуудлыг бол бид нар нийлүүлэлтээр нь л зохицуулна шүү дээ. Жижиг дэлгүүрүүд дээр явж байгаа үнийн нэг бодлогыг хувийн хэвшлийн тэр рүү бид оролцох биш, харин тэр хангамж талд нь нийлүүлэлт нь хомстол, нийлүүлэлтийн шок үүсэхгүй байх тал дээр л Засгийн газар бодлогоо гаргаж ажиллаж байгаа.

**С.Чинзориг:** Энэ онд яах вэ?

**3.Мэндсайхан:** Энэ онд үнэ тогтвортой байлгүй яах вэ. Одоо бид нар 7 сарын 1 хүртэл нөөцийн махаар явах гэж байна шүү дээ. 12.7 мянган тонн мах 100 тэрбум төгрөгөөр бэлдчихсэн явж байгаа. Энэнийхээ 7 сарын 1 гэхэд шинэ мах

гараад ирнэ, зах зээлийнх нь үнээр тавигдлаа, эргээд ахиад мах бэлтгэлийн үеэр нь бид нар энэ асуудлуудаа нөөцлөөд явъя л гэж байгаа. Хэрвээ бид нар энэ нөөцлөлт үүсгээгүй бол, энэ арга хэмжээ авахгүй бол ирэх жилийн нөөц байхгүй, үнэд шууд өсөөд л явна. Энэ мах гурилын зогсоолгүйгээс.

**Ж.Ганбаатар:** Баттөмөр гишүүн асуулт асууя.

**Б.Баттөмөр:** Энэ хомстлоос гээд энэ зөв юм уу, үгүй юу. Урд талд нь зөв байж байснаа хойно нь буруу бичсэн юм шиг байна. Энэ гарчиг нь, хомстлоос гэж энэ дөрвөн гийгүүлэгч нэг дор орчихсон байгаа юм. Энийгээ тодруулаарай, нэгдүгээрт нь.

За яах вэ, одоо ингээд энийг үнийг нь өсөлтөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай гээд бид нэлээн хэдэн хоног ярьчхаж байна л даа. Энэ бол салбарын яамдуудын өөрсдийнх нь хийчих ёстой л ажил л даа. Тэгээд цаашдаа ингээд нэг яваад байх юм уу, яах юм? 1990 оноос хойш өнөөдрийг хүртэл дэлхийн хэмжээнд гэхэд л 100 гаруй хямрал үүссэн байна. Тэгэхээр хямрал бол капиталист нийгмийн, одоо бид нарын явж байгаа нийгмийн сүүдэр шиг дагаж явдаг зүйл бол хямрал даа. Хямрал болгонд л бид хуралдаад л ингээд л цагаа алдаад байх ёстой юу, үгүй юу? Засгийн газарт нь эрхийг нь өгөөд Засгийн газар нь энийгээ тухайн үедээ зохицуулалтуудаа хийгээд яваад байх нь зөв юм биш үү гэсэн нэг ийм санал байна.

Бид одоо ингээд энэ хүнсний хомстол гээд нэг гурван юм дээр л яриад байгаа юм. Тэгээд дараагийн хомстлууд дараагийн хямрал юу байх юм бэ гэж. Дэлхий нийтээрээ ярихдаа экологийн хямрал байж магадгүй гэж ингэж ярьж байна л даа. Манайд маш их олон хямралууд тохиолдож болзошгүй. Тухайлбал, орон сууцны асуудал. Орон сууцны хэрэгцээ, эрэлт маш их байна. Харамсалтай нь энэ дээр төрийн зохицуулалтууд, бодлого гэдэг юм ерөөсөө алга байгаад байгаа юм. Ипотекийн зээлийн хэрэгжилт ямархуу байдалтай байна аа? Би Монголбанкныхнаас асуух гээд байгаа юм. Ипотекийн зээлийн хэрэгжилт ямар байна, цаашдаа ямар бодлого барих гэж байна? Ер нь орон сууцын санхүүжилтийн хэтийн бодлогыг ер нь юу гэж бодож байна вэ? Ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ? Энэ дээр нэг хэлж өгөөч. Тэгээд ер нь бид нар энэ тулга тойрсон асуудал биш, жоохон хэт ирээдүйнхээ юмнуудыг, ирээдүйд болох зүйлүүдээ сэргийлэх, ирээдүйн хөгжлийн гарцуудаа л яримаар санагдаж байгаа юм. Энэ дээр тэгээд дараа дараа нь яригдах юм байгаа биз дээ. Асуултдаа хариулт авъя.

**Ж.Ганбаатар:** 2 номер, Монголбанк Энхжин.

**А.Энхжин:** Баттөмөр гишүүний асуултад хариульяа. Он гарснаас хойш өнөөдрийн байдлаар нийтдээ 135 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 1600 орчим зээлдэгчид олгоод байгаа. Өнгөрсөн онд нийтдээ 1 их наяд төгрөгийн зээлийг 13292 зээлдэгчид олгосон байгаа. Монголбанкнаас энэ ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтээс 2017 оноос эхлээд гарахаар ерөнхийдөө төлөвлөөд ажиллаад Сангийн яамтай холбогдох тушаал, төлөвлөгөөгөө хамтарч батлаад явж байсан. Гэхдээ КОВИД гарсантай уялдуулаад КОВИД-ын хуулийн дагуу Монголбанкнаас 2020 оны 4 сараас хойш ипотекийн хөтөлбөрийг санхүүжүүлээд явж байгаа.

Энэ оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлдээ Монголбанкнаас 2023 онд багтаагаад хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлнэ гээд заалт тусгасан байгаа. Энэ дагуу Монголбанкнаас Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яамтай хамтраад хөтөлбөрийг 2023 онд багтааж шилжүүлэх ажлуудаа хийгээд явж байгаа.

Энэ дагуу бас гадаадын Дэлхийн банкнаас техник техникийн туслалцаа аваад бусад улс орнуудын туршлага, Монголын хувьд тохирсон тийм санхүүжилтийн схем боловсруулах ажлыг бол хамтраад хийгээд ажиллаж байгаа. Тэгэхээр 2023 ондоо багтаагаад Монголбанк ер нь санхүүжилтаасаа гарна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**Ж.Ганбаатар:** Булгаа, ажлын хэсгийн ахлагч гишүүний асуултад хариульяа. 2 минут.

**Х.Булгантуяа:** Энэ, “хомстлоос” гэдгийг шинэ журамласан толиор ингэж бичдэг болчихсон юм байна. Тэгээд бид нар Улсын Их Хурлын Тамгын газар журамласан толийг ашиглах учиртай. Гэхдээ ер нь бол бас энэ журамласан толь иргэд, олон нийтийн дунд монгол хэлний зөв бичгийн дүрмээ одоо үнэнийг хэлэхэд бид нар ч бас ер нь ойлгохоо байлаа шүү. Иргэд, олон нийт чинь их шүүмжилж байна. Бид нар хэзээ ч ингэж дөрвөн гийгүүлэгч хамт хавсарч орохыг ер нь хараагүй. Одоо ингэж бичдэг болсон юм гэнэ ээ, шинэ дүрмээр.

**Ж.Ганбаатар:** Цогтгэрэл гишүүн асуулт асууяа.

**О.Цогтгэрэл:** Үнэ тогтвортжуулах тухай хууль эцэслэн батлагдах гэж байна л даа. Ерөнхийдөө нэрлэж байгаа шалтгаан, шалтаг бол КОВИД, олон улсын хямралт байдал. Яг бодит байдал дээр өнгөрсөн хоёр жилийн хугацаанд КОВИД болоод нөхцөл байдал бол бид нарын экспортын орлогод ордог зэс, нүурс гэдэг бүтээгдэхүүнүүд 2-10 дахин өсчихсөн, аялал жуулчлал олон зүйл дээр магадгүй валютын зөрөө нөлөө гарчихсан. Оростой үнэндээ бид нар чинь эдийн засгийн харилцаа гэж 1.5 тэрбум долларын шатахуун авдаг, 50 сая долларын жонш л гаргадаг. Энэ маань хэвээрээ.

Яг үнэндээ өнгөрсөнд буруутан энэ гадаад нөхцөл байдлыг заахад харин ч бид нар илүү боломжийг алдчихсан ийм л нөхцөл байдалтай. Тэгээд ерөнхийдөө одоо үнийг тогтоон барина гэдэг чинь бараа бүтээгдэхүүн хомстоно. Хоёр янзын үнэ хямдхан мөртөө тэр бараа бүтээгдэхүүн байхгүй болж эхэлдэг нэг ийм л түүх байдаг. Тэгээд тэр ховор зүйл нь магадгүй илүү даргад олддог ийм л үнэ тогтоон барихын үр дагаврууд бас их олон зүйл байдаг. Ерөнхийдөө бид нар шалтгаан талаасаа, бодлого талаасаа бол худалдаанаас болоод тээвэр зууч, худалдааг хөнгөвчлөх олон бодлого гэдэг дээр яг үнэндээ энийг хариуцдаг, ярьдаг албан тушаалтан нь, хууль зүй аль нь ч байхгүй. Тэрийг одоо худалдааны тухай хэнтэй юу ярих юм. Зам барьдаг яам худалдаагаа хариуцдаг, тээвэр ложистик гэдэг тэр хүмүүст падли ч байхгүй нэг ийм л бодлогын хүрээнд л хэрхэн яаж хэнд татаас өгөх вэ гэдэг л асуудал яригдаж байна л даа.

Тэгэхээр энэ Монголбанкнаас нэг асуулт байна. Энэ хуулийн зорилго чинь өөрөө үнийг бас тогтвортжуулах, нөгөө талаасаа валютын нөөцийг тодорхой хэмжээнд хамгаалах зорилготой байх. Тэгэхээр шатахууны импорт гэдэг чинь валютын нөөцөөсөө тодорхой үнээр, өөр үнээр зах зээлийн бус ханшаар валютаа өгөх гэж байна уу? Яг энэний цаана яг үнэ дээр яаж нөлөөлөх гэж байгаа юм? Тэгээд тэрэнд нь хэдий хэмжээний валютыг тооцож байгаа юм? Энэ валют нь Монголбанк хаанаас гарах юм, төсөвт суух юу, хойшдоо энэ үнийн зөрүү, валютын зөрүү ханш. Энэ чинь өөр арга байхгүй байлгүй дээ. Яг энэ бодлого дээр шатахуун дээр хэрвээ үнэ өсвөл. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

**Ж.Ганбаатар:** Энхжин Монголбанк, ажлын хэсгийн 2 номерын микрофон ёгье.

**А.Энхжин:** Өмнө нь Монголбанкнаас хэрэгжүүлсэн Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд шатахууны үнийг тогтвортой тогтвортой байлгах зорилгоор шатахуун импортлогч компаниудад банкаар дамжуулаад зах зээлийн үнээс нь доогуур ханшаар валют нийлүүлж байсан. Үүнээс шалтгаалаад Монголбанканд балансын маш их хэмжээний алдагдал үүссэн. Хоёрдугаарт бас зах зээл дээр гажуудал үүсгэх тийм сөрөг нөлөө байсан. 2016 оноос хойш ерөнхийдөө энэ төрлийн ажиллагааг Монголбанкнаас зогсоосон байгаа. Одоо хийхээр төлөвлөж байгаа ажил нь бол яг зах зээлийн зарчимд суурилсан төгрөг, ам.долларынхаа зах зээлийн хүүгээр форвард ханшийг тооцоод арилжааны банкаар дамжуулаад шатахуун имортлогч компаниудад гурав хүртэл сарын хугацаатай үүсмэл хэрэгсэл санал болгох юм. Энэ гурван сарын хугацаатай уусмал хэрэгслээрээ ханшаа тодорхой хэмжээнд удирдах боломжийг нь бол олгож байгаа. Тэрнээс биш эрсдэлээс 100 хувь сэргийлэх гээд байгаа тийм зүйл бол байхгүй.

**Ж.Ганбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гүйцээж хариулья.

**Х.Булгантуяа:** Цогтгэрэл гишүүн чухал нэг асуудлыг яг хөндөж байна. Манайх яг Худалдааны тухай хууль хүртэл байхгүй байгаад байгаа. Энэ уг нь бол орж ирэх ёстой, батлуулах ёстой хуулийн нэг. Хил гааль, хаалттай энэ хүнд нөхцөлд бид нар ядаж хууль, эрх зүйн орчноо сайжруулаад бэлтгэл ажлаа хангаад дотоодынхоо компаниудыг бэлтгээд, чадавхжуулаад нэг өдөр хэл нээгдэхэд бүх юм бэлэн гарахад бэлэн болгох энэ юмнуудаа уг нь бид нар хийж байх ёстой юм. Тэгээд Улсын Их Хурлаас, тэр тусмаа Эдийн засгийн байнгын хорооноос Худалдааны хуулияа яаралтай боловсруулж оруулж ирээч гэдэг чиглэл бид нар өгч бас болох байх аа даа. Тэгээд үүн дээр бас Эдийн засгийн байнгын хороон дээр анхаараад дараа чиглэл өгвэл.

**Ж.Ганбаатар:** Асуулт асуугаад дууслаа. Худалдааны хууль дээр Их Хурлаас бэлтгэх ажлын хэсэг гарчихсан, Өнөрболов гишүүн ахалчихсан явж байгаа. Булгаа дарга сайн мэдэж байгаа байх. Тэр ажлын хэсэгт би бас шахаж хэлье.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслөөр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй. Гишүүдээс бас зарчмын зөрүүтэй санал ирсэнгүй. Өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө. Танилцуулгыг нэгдсэн хуралдаанд Булгантуяа гишүүн уншина. Баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ